

МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ХООРОНД СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛИЙН ХАРИЛЦАА ТОГТООХ ТУХАЙ ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Нэг. Монгол Улсын Ерөнхий сайд Сүхбаатарын Батболд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябаогийн урилгаар 2011 оны 6 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд БНХАУ-д албан ёсны айлчлал хийв.

Хоёр. Айлчлалын үеэр Ерөнхий сайд С.Батболд Ерөнхий сайд Вэнь Зябаотай хэлэлцээ хийж, БХАТИХ-ын Байнгын хорооны дарга У Бангуо, БНХАУ-ын Дэд дарга Си Жиньпин нартай тус тус уулзав. Хоёр улсын удирдагчид найрсаг, элэгсэг дотно уур амьсгалд хоёр улсын харилцааны болон харилцан сонирхсон олон улс, бүс нутгийн өргөн хүрээтэй асуудлаар санал бодлоо нухацтай солилцож, нэгдмэл ойлголтод хүрэв.

Гурав. Монгол, Хятад нь урт газраар хил залган оршдог найрсаг хөрш орнууд бөгөөд Монгол, Хятадын найрсаг харилцааг тасралтгүй бэхжүүлэн гүнзгийрүүлэх нь хоёр улс, хоёр ард түмний эрх ашигт нийцэх төдийгүй тус бүс нутгийн энх тайван, тогтвортой байдал, хөгжилд тустай гэж талууд санал нэгтэй үзэв. 2003 онд Монгол, Хятадын сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцаа тогтоосноос хойш хоёр улсын бүх салбарын харилцаа, хамтын ажиллагаа хэлбэрэлтгүй гүнзгийрч, хоёр улсын хөгжил, ард түмний сайн сайхны үйлсэд тус нэмрээ оруулсныг талууд сэтгэл

ханамжтай тэмдэглэв.

Монгол, Хятадын сайн хөршийн найрсаг, харилцан ашигтай хамтын ажиллагааг улам бүр бэхжүүлэхийн тулд талууд Монгол, Хятадын сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцааг Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцаа болгон дээшлүүлж, дор дурдсан тэргүүлэх салбаруудын хамтын ажиллагааг бэхжүүлэхээр шийдвэрлэв.

1. Улс төрийн хэлхээ холбоо, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх замаар Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааны улс төрийн үндсийг хэлбэрэлтгүй бэхжүүлнэ.

Монгол Улстай найрсаг харилцаа хөгжүүлэх нь БНХАУ-ын Засгийн газрын стратегийн тууштай чиг шугам болохыг хятадын тал нотлов. БНХАУ-тай найрсаг харилцаа, хамтын ажиллагааг бүх талаар өргөжүүлэн хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болохыг монголын тал нотлов.

Талууд бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал сонгонавсан хөгжлийн замыг харилцан хүндэтгэхээ нотлов. Талууд бие биеийн эсрэг чиглэсэн цэрэг, улс төрийн аливаа эвсэлд оролцохгүй, нөгөө талын төрийн бүрэн эрхт байдал, аюулгүй байдалд хохирол учруулах ямар нэгэн гэрээ, хэлэлцээрийг гуравдагч улстай байгуулахгүй, нөгөө талын бүрэн

эрхт байдал, аюулгүй байдлыг хохироохоор өөрийн нутаг дэвсгэрийг гуравдагч улсад ашиглуулахгүй.

Монголын тал БНХАУ-ын Засгийн газар бол нийт Хятад улсыг төлөөлөх цорын ганц хууль ёсны Засгийн газар гэж үздэг бөгөөд Тайваний асуудал, Түвд, Шинжаантай холбоотой асуудлаарх хятадын талын зарчмын байр суурийг тууштай дэмждэгээ нотлов. Монголын цөмийн зэвсэггүй статус болон үндэсний аюулгүй байдал, язгуур эрх ашгаа улс төр, дипломатын аргаар хангах монголын талын хүч чармайлтыг дэмждэгээ хятадын тал нотлов.

Дээд, өндөр түвшний айлчлал, уулзалт нь хоёр талын харилцааны хөгжилд онцгой чухал ач холбогдолтой гэж талууд үзэв. Талууд дээд, өндөр түвшний айлчлал, уулзалтын давтамжийг хадгалж, олон улсын олон талт арга хэмжээг идэвхтэй ашиглан хоёр улсын удирдагчдын уулзалтыг хийж, стратегийн хэлхээ холбоог бэхжүүлнэ. Талууд хоёр улсын парламент, засгийн газар болон улс төрийн намуудын солилцоо, хамтын ажиллагааг улам бүр бэхжүүлнэ.

Талууд батлан хамгаалах, аюулгүй байдлын салбарын солилцоо, хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэхээр тохиров. Терроризм, хар тамхи, хүний наймаа зэрэг улс дамнасан гэмт хэргийн эсрэг хамтран тэмцэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хохирлыг бууруулах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зэрэг салбарт хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

2. Эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлж, харилцан ашигтай, хамтаар хожих хамтын ажиллагааг тогтвортой хөгжүүлж, хамтын

хөгжлийг урагшлуулах нь Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааны өнө удаан хугацааны хөдөлгөгч хүч байх болно.

Өөрийн улсын эдийн засгийн хөгжлийн стратегийн үндсэн дээр хоёр талын худалдааны бүтцийг сайжруулж, харилцан хөрөнгө оруулалтыг дэмжиж, хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтын тогтвортой өсөлтийг хадгалахаа талууд илэрхийлэв. Талууд Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны дунд хугацааны хөтөлбөрийг идэвхтэй хэрэгжүүлж, Эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааны засгийн газар хоорондын комисс, Уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагааны комисс болон бусад хамтын ажиллагааны механизмыг сайтар ашиглаж хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг цэгцтэй хөгжүүлнэ. Байгаль орчинд ээлтэй, өндөр технологид тулгуурласан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийг бодлогоор дэмжихээр талууд тохиров.

Байгалийн баялгийг нээн ашиглах, дэд бүтцийн бүтээн байгуулалт нь хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл гэдгийг нотлохын зэрэгцээ уул уурхай, эрчим хүч, хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагаанд онцгой ач холбогдол өгч байгааг талууд илэрхийлэв.

Талууд уул уурхай, эрчим хүчний баялгийг нээн олборлох, дэд бүтцийн бүтээн байгуулалт, санхүүгийн хамтын ажиллагааг уялдуулан цогц байдлаар хөгжүүлэх зарчмын дагуу хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх нь зүйтэй гэж үзэв. Монголын тал Хятадын аж ахуйн нэгжүүдийг Монголын нүүрс, зэс, төмөр, газрын тос, ураны орд зэрэг уул

уурхай, эрчим хүчний төслүүд болон дэд бүтэц, орон сууцны бүтээн байгуулалтын хамтын ажиллагаанд оролцохыг дэмжиж, хоёр улсыг холбосон төмөр зам, авто зам барьж байгуулахад хятадын талтай хамтын ажиллагааг бэхжүүлэхэд бэлэн байгааг илэрхийлэв.

Газрын тосны бэлэн бүтээгдэхүүн нийлүүлэх, газрын тос боловсруулах үйлдвэр барих, цахилгаан эрчим хүчний худалдаа, түүхий эд гүн боловсруулах, транзит тээвэр, далайд гарах гарц зэрэг чиглэлд монголын талтай харилцан ашигтай хамтын ажиллагааг үргэлжлүүлж, дэмжлэг туслалцаа үзүүлэхэд бэлэн байгааг хятадын тал илэрхийлэв. Байгалийн хийн хоолой, өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамыг Монголын нутгаар дамжин өнгөрүүлэх асуудлаар талууд санал солилцов.

Хилийн боомтын хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, нэвтрэх хүчин чадлыг дээшлүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах механизмыг илүү боловсронгуй болгож, идэвхжүүлэхээ талууд илэрхийлэв.

БНХАУ-ын Засгийн газраас олгож ирсэн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд чухал дэмжлэг болж ирснийг монголын тал тэмдэглэн чин сэтгэлийн талархал илэрхийлэв. Хятадын тал цаашид ч бололцооныхоо хэрээр монголын талд тусламж үзүүлэхэд бэлэн байгаа бөгөөд энэ нь Монголын эдийн засаг, нийгмийн хөгжилд түлхэц үзүүлж, хоёр талын найрсаг харилцааг урагшлуулахад идэвхтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байгааг илэрхийлэв.

3. Хүмүүнлэгийн солилцоог гүнзгийрүүлж, иргэд хоорондын найрсаг

хандлагыг нэмэгдүүлэн, Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааны нийгмийн үндэс суурийг бэхжүүлнэ.

Соёл, боловсрол, эрүүл мэнд зэрэг салбарын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэхээ талууд нотлов. Монголын тал Хятадад соёлын төв байгуулахад холбогдох дэмжлэг үзүүлэх, Монголд их, дээд сургуулийн хотхон байгуулахад идэвхтэй оролцох, соёлын биет бус өвийг хамгаалах чиглэлд монголын талтай хамтын ажиллагааг бэхжүүлэхэд бэлэн байгааг хятадын тал илэрхийлэв. Кунзийн институт, Монгол дахь Хятадын соёлын төвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн дэмжихээ монголын тал илэрхийлэв.

Хүүхэд, залуучуудын солилцоог бэхжүүлэх нь хоёр улсын харилцааны ирээдүйн хөгжилд стратегийн ач холбогдолтой. Хэвлэл, мэдээллийн байгууллагуудын солилцоо нь хоёр орны харилцаанд олон нийтийн таатай уур амьсгал бүрдүүлэх тул түүнд чухал ач холбогдол өгч түлхэц үзүүлэх нь зүйтэй гэж талууд үзэв. Хоёр улсын хүүхэд, залуучуудын төлөөлөгчдийн харилцан айлчлалыг идэвхтэй хэрэгжүүлж, цар хүрээг нь аажмаар өргөтгөн улмаар механизм бий болгох, мөн хэвлэл, мэдээллийн байгууллагуудын төлөөлөгчдийн харилцан айлчлалын механизм бий болгохоор тогтов.

Талууд хоёр улсын иргэд харилцан зорчих явдал өдрөөс өдөрт өргөжиж байгаад сэтгэл ханамжтай байгааг илэрхийлэхийн хамт иргэдийн солилцоонд холбогдох асуудлыг хариуцдаг байгууллагууд хоорондын хэлхээ холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлж, хамтын ажиллагааны механизм болон холбогдох үйлчилгээг сайжруулж, иргэд

харилцан зорчих явцад үүссэн асуудлуудыг түргэн шуурхай, зохистой шийдвэрлэх, өөрийн улсын нутаг дэвсгэрт нөгөө талын иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тохиров.

Талууд Монгол Улсын Ерөнхий консулын газар БНХАУ-ын Засаг захиргааны тусгай бүс Гонконг-д нээгдсэнд баяртай байгааг илэрхийлээд, цаашид консулын харилцааг бэхжүүлэхээр болов.

Хүрээлэн буй орчныг хамгаалах, дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт болон шар шороон шуургатай тэмцэх чиглэлд мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг бэхжүүлэхээ талууд илэрхийлэв.

4. Олон улс болон бүс нутгийн асуудлаар харилцан зохицуулалт, дэмжлэгээ нэмэгдүүлж, хамтын ашиг сонирхлоо хамгаалан Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааны агуулгыг тасралтгүй баяжуулна.

Олон улс болон бүс нутгийн үйл хэрэгт харилцан итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэн, яриа хэлцээний замаар маргааныг шийдвэрлэх зарчмыг тууштай баримталж, шударга, ардчилсан, зүй зохистой олон улсын улс төр, эдийн засгийн дэг журмыг хамтран бий болгохын төлөө байгааг талууд илэрхийлэв.

Дэлхий дахинд энх тайвныг хангах, хамтын хөгжлийг түргэтгэх, олон улсын хамтын ажиллагааг урагшлуулахад НҮБ тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байгааг дэмждэгээ талууд нотлов.

Дэлхий дахины болон Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэхийн төлөө байгааг талууд нотлов.

Монголын талыг Зүүн хойд Ази, Зүүн Азийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох, АПЕК-т элсэхийг хятадын тал дэмжиж буйг илэрхийлэв. Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Олон улсын судалгааны төвийг НҮБ-ын дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотноо байгуулж байгаад хятадын тал баяр хүргэв. Бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хангахад оруулж буй хятадын талын чухал хувь нэмрийг монголын тал өндрөөр үнэлж, зургаан талт яриа хэлэлцээг аль болох эрт сэргээхийг дэмжиж байгааг илэрхийлж, БНХАУ, Япон Улс, БНСУ-ын гурван талт хамтын ажиллагаа тасралтгүй бэхжин хөгжиж байгаад баяр хүргэв.

Монгол Улс нь Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын анхны ажиглагч улсын хувьд тус байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож буйг хятадын тал сайшаагаад, тус байгууллагын бусад гишүүн улстай бодит хамтын ажиллагаа хөгжүүлэхэд монголын талыг идэвхтэй дэмжихэд бэлэн байгааг илэрхийлэв. Хятадын тал болон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн бусад улстай хамтын ажиллагааг бэхжүүлж, Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын хөгжилд идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд бэлэн байгааг монголын тал илэрхийлэв.

Дөрөв. Айлчлалын үеэр талууд “БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 500 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн ерөнхий хэлэлцээр”, “Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”, “Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын авто

тээврийн хэлэлцээр”, “Соёлын өвийг хууль бусаар хил давуулах, соёлын дурсгалт газар хууль бусаар малтлага хийх, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хулгайд алдагдахаас сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”, “Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам болон БНХАУ-ын Боловсролын яамд хоорондын 2011-2016 онд хэрэгжүүлэх боловсролын солилцоо, хамтын ажиллагааны төлөвлөгөө”, “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс болон БНХАУ

хоорондын гэрээ” зэрэг баримт бичигт гарын үсэг зурав.

Тав. Ерөнхий сайд С.Батболдын энэ удаагийн айлчлал амжилттай болж, хоёр улсын харилцааны хөгжлийг улам бүр урагшлуулахад чухал ач холбогдолтой боллоо гэж талууд санал нэгтэй үзэв. Халуун дотно хүлээн авч, айлчлалыг өндөр түвшинд зохион байгуулсан хятадын талд Ерөнхий сайд С.Батболд гүн талархал илэрхийлэв.

2011 оны 6-р сарын 21